



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 409

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны
зохицуулалтын журам, заавар батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар"-ыг 2 дугаар хавсралтаар, "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоход цаашид энэ журмыг баримтлах ба энэ журам батлагдахаас өмнө тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа ББСБ-ын хувьд эрхлэх үйл ажиллагааныхаа төрөл, чиглэлийг энэ журмын шаардлагад 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дотор нийцүүлж, тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэл хийлгэхийг ББСБ-уудын удирдлагуудад даалгасугай.

3. Энэ журам батлагдсантай холбогдуулан одоо итгэлцлийн үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-ууд нь Хорооны шинэчилсэн бүртгэлд бүртгүүлэхгүйгээр харилцагчтай байгуулсан итгэлцлийн гэрээний хугацааг сунгахгүй, шинээр итгэлцлийн гэрээ байгуулж, нэмж итгэлцлээр эх үүсвэр татахгүй байхыг ББСБ-уудын удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Хорооны 2008 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний зохицуулалтын журам", 162 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд журам боловсруулах заавар", 186 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам", 2011 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх журам", 2012 оны 248 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам"-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тогтоолыг 2015 оны 12 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

001094

6. Журам, заавруудыг нэг мөр ойлгож хэрэглэх, програмын нөхцөлд нийцүүлж турших, шалгах, мөрдүүлж хэвшүүлэх талаар хамтарсан ажлын төлөвлөгөө гаргаж ажиллахыг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд, Бичил санхүүгийн зохицуулалтын газар /Н.Оюунчимэг/-т, Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т тус тус даалгасугай.

7. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



ЗНАРАНГУЯА



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 409

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны
зохицуулалтын журам, заавар батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар"-ыг 2 дугаар хавсралтаар, "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоход цаашид энэ журмыг баримтлах ба энэ журам батлагдахаас өмнө тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа ББСБ-ын хувьд эрхлэх үйл ажиллагааныхаа төрөл, чиглэлийг энэ журмын шаардлагад 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дотор нийцүүлж, тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэл хийлгэхийг ББСБ-уудын удирдлагуудад даалгасугай.

3. Энэ журам батлагдсантай холбогдуулан одоо итгэлцлийн үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-ууд нь Хорооны шинэчилсэн бүртгэлд бүртгүүлэхгүйгээр харилцагчтай байгуулсан итгэлцлийн гэрээний хугацааг сунгахгүй, шинээр итгэлцлийн гэрээ байгуулж, нэмж итгэлцлээр эх үүсвэр татахгүй байхыг ББСБ-уудын удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Хорооны 2008 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний зохицуулалтын журам", 162 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд журам боловсруулах заавар", 186 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам", 2011 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх журам", 2012 оны 248 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай ерийн бичгийг бүртгэх журам"-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тогтоолыг 2015 оны 12 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

001095

6. Журам, заавруудыг нэг мөр ойлгож хэрэглэх, програмын нөхцөлд нийцүүлж турших, шалгах, мөрдүүлж хэвшүүлэх талаар хамтарсан ажлын төлөвлөгөө гаргаж ажиллахыг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд, Бичил санхүүгийн зохицуулалтын газар /Н.Оюунчимэг/-т, Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т тус тус даалгасугай.

7. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



ЗНАРАНТУЯА



БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлох, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулахад оршино.

1.2. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах, баримт бичиг бүрдүүлэх болон баримт бичгийг хүлээн авах, хянах зааврыг Хорооны тогтоолоор батална.

1.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-7.1.11 дэх заалтад заасан үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тусгай зөвшөөрлийг тухайн этгээдийн эрхлэх үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн дараах чиглэлээр төрөлжүүлэн олгоно. Үүнд:

- 1.3.1. Гадаад валютын арилжаа эрхлэх;
- 1.3.2. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх;
- 1.3.3. Итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эрхлэх.

1.4. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь тусгай зөвшөөрөл тус бүрийн хүрээнд энэ журмаар тогтоосны дагуу Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-7.1.11 дэх заалтад заасан үйл ажиллагааг дагнан, хавсран эсхүл төрөлжүүлэн эрхэлж болно. Банк бус санхүүгийн үйл ажиллагааг дагнан, хавсран эсхүл төрөлжүүлэн эрхэлж байгаа хуулийн этгээд нь Компанийн тухай хуульд зааснаар компаниудын нэгдлийн оролцогч байж болно.

1.5. Тусгай хуулиар үйл ажиллагаа нь зохицуулагддаг, үйл ажиллагааныхаа хүрээнд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.8, 7.1.9, 7.1.10, 7.1.11-д заасан үйл ажиллагааг эрхлэх эрхтэй санхүүгийн байгууллагууд /Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.11-д заасан тусгай зориулалтын компани, 20 дугаар зүйлд заасан хөрөнгө итгэмжлэн удирдагч, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.1.2-т заасан хувийн хөрөнгө оруулалтын санг удирдах этгээд/-ын анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан гэрээнийхээ дагуу хөрөнгийг итгэмжлэн удирдах, захиран зарцуулахтай холбоотой харилцааг нь тухайн тусгай хууль, журмаар нь зохицуулах бөгөөд эдгээр хууль, журмаар нь зохицуулаагүй хөрөнгө итгэмжлэн удирдах, захиран зарцуулахтай холбоотой харилцаанд энэ журмыг баримталж болно.

1.6. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрөл, чиглэлд хамаарах зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ болон бусад нөхцөл, хязгаарлалтыг олон улсын стандартад нийцүүлэн Хороо тогтоох ба хэрвээ ББСБ нь компанийн нэгдлийн оролцогч бол нийт нэгдлийн оролцогч бусад санхүүгийн байгууллагуудыг хамруулан эдгээр шалгуурыг тогтоож, тооцно.

1.7 Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгохдоо Хороо дараах зарчмыг баримтална. Үүнд:

1.7.1. Алслагдсан дүүрэг, хөдөө орон нутагт хямд өртөгтэй олон төрлийн санхүүгийн үйлчилгээг иргэдэд хүргэх ББСБ-уудыг дэмжих бодлого, зохицуулалт, хэм хэмжээг тогтоох;

1.7.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан хүрээнд олон улсын санхүүгийн байгууллагуудын гаргасан зөвлөмж, аргачлал, стандартад нийцсэн зохицуулалтыг бий болгох;

1.7.3. Санхүүгийн олон төрлийн ажил үйлчилгээг мэргэжлийн түвшинд дагнан, хавсран, эсхүл төрөлжүүлэн хүргэдэг активын удирдлагыг эрсдэлгүй хэрэгжүүлэх чадавхи бүхий санхүүгийн байгууллагыг хөгжүүлж, шудрага өрсөлдөөнт, тогтвортой, хүртээмжтэй зах зээлийн орчинг бий болгох.

ХОЁР. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

2.1.1. “факторингийн үйлчилгээ” гэж зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах /шилжүүлэх/, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаврыг бүрэн хариуцах үйл ажиллагааг;

2.1.2. “төлбөрийн баталгаа гаргах” гэж Иргэний хуулийн 457 дугаар зүйлд заасныг;

2.1.3. “цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ” гэж бусдын мөнгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, эсхүл интернет, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж, төлбөр тооцоог нь гүйцэтгэх ажиллагааг;

2.1.4. “төлбөр тооцооны хэрэгсэл гаргах” гэж зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд зээл, факторингийн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд түүний харилцагч хооронд хийгдэх төлбөр тооцоо (зээл олгох, төлөх, факторингийн төлбөрийг цуглуулах гэх мэт)-г гүйцэтгэх зорилгоор тухайн ББСБ-аас харилцагчдад зориулж дебет, кредит карт, түүнтэй адилтгах төлбөр тооцооны хэрэгсэл гаргахыг;

2.1.5. “гадаад валютын арилжаа” гэж гадаад валютыг худалдах, худалдан авах үйл ажиллагааг;

2.1.6. “богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх” гэж тодорхой гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийн эх үүсвэрийг нэг жил хүртэл хугацааны хөрөнгө оруулалтын үнэт цаас болон үүнтэй адилтгах санхүүгийн хэрэгсэлд хөрвүүлэхийг;

2.1.7. “итгэлцлийн үйлчилгээ” гэж итгэл хүлээлгэгчийн актив /бэлэн мөнгө, зээл, бусад актив/-ыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор тэдгээртэй

харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр итгэл хүлээгчээс нэр бүхий активыг түр хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааг;

2.1.8. “нэр бүхий активыг түр хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах” гэж итгэл хүлээлгэгчийн активыг Хорооноос болон итгэл хүлээлгэгчийн хүлээн зөвшөөрсөн хэлбэрээр энэ журмын 6.8 дах заалтад заасан актив хөрөнгөд байршуулж удирдахыг;

2.1.9. “хоёрдогч өглөг” гэж өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор гэрээнд заасан хугацаа дууссаны эцэст хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаанд хөрвүүлэх нөхцөлтэй, 3-дагч этгээдээс авсан, захиран зарцуулалт нь хязгаарлагдмал мөнгөн хөрөнгийг;

2.1.10. "гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ" гэж Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан нөхцөлийн дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн хувьцаа, хувь нийлүүлсэн хөрөнгөд гадаадын иргэн, хуулийн этгээд хөрөнгө оруулсан Хорооноос энэ журмын дагуу тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийг;

2.1.11. “гадаадын ББСБ” гэж гадаад улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллагаас 100 хувь хөрөнгө оруулсан, Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулахаар Хорооноос энэ журмын дагуу тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийг.

ГУРАВ. БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг Компанийн тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулна.

3.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг Компанийн тухай хуулийн 13, 18 дугаар зүйлд заасны дагуу хувь нийлүүлэх, хувьцаа гаргах, хувьцааны захиалга авах аргаар болон нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх (цаашид өөрчлөн байгуулах гэх) замаар, хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулж болно.

3.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн этгээд нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг болон 13 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

3.4. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ болон гадаадын ББСБ-д Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан шаардлагыг тавих бөгөөд шаардлагатай гэж үзвэл Хорооноос нэмэлт шаардлага тавьж болно.

3.5. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа тус бүрийг нарийвчлан зохицуулсан бодлогын баримт бичиг, журам, зааврыг баталж, мөрдөн ажиллана.

3.6. Хувьцаа эзэмшигчдээс Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь тухайн иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны үйл ажиллагаанаас олсон цэвэр ашиг болон үйл ажиллагааны тогтвортой бодит орлогоос бүрдсэн байна.

3.7. Хорооноос баталсан журмын дагуу жил бүр болон тухай бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоосон хэмжээгээр хугацаанд нь төлнө.

ДӨРӨВ. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

4.1. Гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах үйл ажиллагааг эрхэлж болно. Үүнд:

4.1.1. гадаад валютын арилжаа;

4.1.2. цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ;

4.2. Гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авахдаа энэ журмын 4.1.1-4.1.2-т заасан үйл ажиллагааг бүхэлд нь эрхэлж болох бөгөөд журмын 4.3, 4.4-т заасан шаардлагыг хангасан байна.

4.3. Гадаад валютын арилжаа эрхлэх хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.3.1. ажилтны аюулгүй байдлыг хангасан торон /шилэн/ хаалттай байх;

4.3.2. бичсэн бичлэгийг 1 сараас доошгүй хугацаагаар архивлан хадгалдаг хяналтын камертай байх;

4.3.3. гадаад валютыг худалдах, худалдан авах тухай бүр баримт үйлдэж, тооцооллыг хийх боломжтой санхүүгийн програм, кассын машинтай байх;

4.3.4. тухайн төрлийн валютыг шалгагч болон мөнгө тоологч машинтай байх;

4.3.5. гадаад валютыг худалдан авах, худалдах ханшийг нийтэд ил тод мэдээлэх самбартай байх.

4.4. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа эрхлэхэд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.4.1. ашиглах төлбөрийн хэрэгсэл нь төлбөр тооцооны үйлчилгээний шаардлагуудыг хангаж, Монголбанкнаас хэлбэлгдэх зөвшөөрөл авч, дүгнэлт гаргуулсан байх;

4.4.2. үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, програм хангамжтай байх;

4.4.3. төлбөр тооцооны системээр дамжиж байгаа болон хадгалагдаж буй төлбөр тооцооны хэрэгслийн болон хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чадвартай байх;

4.4.4. системийн тасралтгүй ажиллагааны зохицуулалт буюу онцгой байдлын төлөвлөгөө, нөөц төв, түүний техникийн зохистой үзүүлэлтийг хангасан байх.

4.5. Гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авахдаа энэ журмын 4.1.1-4.1.2-т заасан үйл ажиллагааг хамтаар нь эрхлэхээр аваагүй, аль нэгийг нь нэмж эрхлэх хүсэлтэй бол журмын 4.3, 4.4-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.5.1. Хорооноос энэ ангиллын тусгай зөвшөөрөл авснаас хойш 1-ээс доошгүй жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;

4.5.2. Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 6 сарын хугацаанд хангаж ажилласан байх;

4.5.3. Хорооноос тухайн ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварт хийсэн зайны хяналтаар “Бага эрсдэлтэй” гэж үнэлэгдсэн, газар дээрх шалгалтаар хангалттай үнэлгээ авсан байх.

ТАВ. ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

- 5.1.1. зээл;
- 5.1.2. факторингийн үйлчилгээ;
- 5.1.3. төлбөрийн баталгаа гаргах;
- 5.1.4. гадаад валютын арилжаа;
- 5.1.5. цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ;
- 5.1.6. төлбөр тооцооны хэрэгсэл гаргах;
- 5.1.7. богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх;
- 5.1.8. хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх.

5.2. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд энэ журмын 5.1-д заасан үйл ажиллагааг бүгдийг эсхүл дангаар болон зарим хэсгийг хавсран эрхлэхээр олгож болно.

5.3. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд энэ журмын 5.1.1-5.1.8-д заасан үйл ажиллагааг бүгдийг эрхлэх бол энэ журмын 4.3, 4.4, 5.5, 5.6-д заасан шаардлагыг хангасан байна.

5.4. Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагаа эрхлэхэд энэ журмын 4.4-т заасан шаардлагыг хангасан байна.

5.5. Зээл, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэхэд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.5.1. Монголбанкны Зээлийн мэдээллийн сантай гэрээ байгуулсан байх;

5.5.2. эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах дүрэм журам нь тодорхой, энэ чиглэлээр мэргэжлийн, чадвартай хүний нөөцтэй байх;

5.5.3. санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх энэ чиглэлээр мэргэшсэн ажилтантай байх;

5.5.4. үйл ажиллагааны шаардлагыг хангасан техник, тоног төхөөрөмж, програм хангамжтай байх.

5.6. Факторингийн үйлчилгээ, төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэхэд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.6.1. хууль, эрх зүйн болон санхүүгийн чиглэлээр мэргэшсэн ажилтантай байх;

5.6.2. төлбөрийн баталгааны гэрээ нь Иргэний хуулийн 457 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангасан байх.

5.7. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд нэмж үйл ажиллагаа эрхлэх бол энэ журмын 5.3-т заасан шаардлагыг хангахаас гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.7.1. тусгай зөвшөөрөл авснаас хойш 1-ээс доошгүй жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;

5.7.2. Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 6 сарын хугацаанд хангасан байх;

5.7.3. Хорооноос тухайн ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварын үйл ажиллагаанд зайнаас хийсэн хяналт шалгалтаар “Бага эрсдэлтэй” гэж үнэлэгдсэн, газар дээрх хяналт шалгалтаар хангалттай үнэлгээ авсан байх.

5.8. Энэ журмын 4.1-д заасан гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ нь энэ журмын 5.1-д заасан зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авч болох бөгөөд энэ тохиолдолд зээлийн үйл ажиллагаанд тавигдсан шаардлагыг хангасан байна. Хорооноос зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгосон тохиолдолд гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүйд тооцно.

ЗУРГАА. ИТГЭЛЦЭЛ, ХӨРӨНГӨ УДИРДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

6.1. Итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

6.1.1. итгэлцлийн үйлчилгээ;

6.1.2. факторингийн үйлчилгээ;

6.1.3. гадаад валютын арилжаа;

6.1.4. богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх;

6.1.5. хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх;

6.1.6. үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа.

6.2. Итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо энэ журмын 6.1-д заасан үйл ажиллагааг бүгдийг эсхүл дангаар болон зарим хэсгийг хавсран эрхлэхээр олгож болно.

6.3. Итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд энэ журмын 6.1.1-6.1.6-д заасан үйл ажиллагааг бүгдийг эрхлэх бол энэ журмын 4.3, 5.5.2-5.5.4, 5.6, 6.4-т заасан шаардлагыг хангасан байна.

6.4. Итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах шаардлагыг хангасан тохиолдолд олгоно. Үүнд:

6.4.1. итгэл хүлээлгэгчийн активыг хянах, ашиглах, захиран зарцуулах доод хугацаа 1 жилээс доошгүй байх;

6.4.2. хөрөнгө (мөнгө, бусад актив) итгэмжлэн удирдах дүрэм, журамтай, хөрөнгийг удирдах туршлага бүхий, эрсдэлийн үнэлгээ, активын удирдлагын суурь тооцооллыг хийх чадвартай, санхүү, хөрөнгө оруулалт, хууль эрх зүйн салбарт 5-аас доошгүй жил ажиллаж мэргэшсэн боловсон хүчин, хүний нөөцтэй;

6.4.3. итгэл хүлээгчээс итгэл хүлээлгэгчтэй хийсэн итгэлцлийн гэрээ (хөрөнгө итгэмжлэн удирдах)-ний дагуу түүний зөвшөөрсөн үнэт цаасны багц болон хөрөнгө оруулалтын санг удирдах бол Хорооноос хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байх;

6.4.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хуулийн 12 дугаар зүйлд заасан тусгай зориулалттай компанийн хөрөнгийг удирдах бол тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан байх;

6.4.5. үйл ажиллагааны шаардлагыг хангасан техник, тоног төхөөрөмж, програм хангамжтай байх.

6.5. Гадаад валютын арилжаа болон зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ нь итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эрхлэх ББСБ үүсгэн байгуулж, тусгай зөвшөөрөл авч болох бөгөөд энэ тохиолдолд шинээр үүсгэн байгуулсан ББСБ нь энэ журмын 6.4-д заасан шаардлагыг хангаж ажиллана. Түүнийг үүсгэн байгуулж байгаа ББСБ нь дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

6.5.1. үүсгэн байгуулагч ББСБ нь өмнө авсан тусгай зөвшөөрлийн хүрээнд 3-аас доошгүй жилийн хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;

6.5.2. Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 6 сарын хугацаанд хангасан байх;

6.5.3. Хорооноос тухайн ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварт хийсэн зайны хяналтаар “Бага эрсдэлтэй” гэж үнэлэгдсэн, газар дээрх шалгалтаар хангалттай үнэлгээ авсан байх.

6.6. Гадаад валютын арилжаа, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ үйл ажиллагааны төрөл, чиглэлээ өөрчилж, энэ журмын 6.5-д заасны дагуу Хорооноос итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан тохиолдолд тухайн ББСБ-ын гадаад валютын арилжаа болон зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцно.

6.7. Гадаад валютын арилжаа, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ нь итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эрхлэх өөрийн охин, хараат, зэргэлдээ компани буюу нэгдлийн оролцогч хуулийн этгээд үүсгэн байгуулж, тусгай зөвшөөрөл авч болно. Энэ тохиолдолд гадаад валютын арилжаа, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын өмнө авсан тусгай зөвшөөрөл хэвээр үлдэнэ.

6.8. Итгэлцэл, хөрөнгө удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ нь хөрөнгө (мөнгө, үнэт цаас, бусад актив)-ийг дараах хэлбэрээр удирдана. Үүнд:

6.8.1. зээлийн багц, картын төлбөр, орон сууцны түрээс, санхүүгийн түрээсийн авлага, хадгаламжийн сертификат зэрэг хуулиар итгэмжлэн удирдахыг хүлээн зөвшөөрсөн актив хөрөнгийг багцалж, түүнд суурилсан өрийн хэрэгсэл гаргах;

6.8.2. мөнгөн хөрөнгө (өрийн хэрэгслийг худалдан борлуулснаас олсон, эсхүл итгэл хүлээлгэгчээс итгэлцлийн гэрээний дагуу удирдуулахаар өгсөн)-ийг богино хугацаат үнэт цаасанд байршуулах;

6.8.3. Хорооноос тогтоосон зохистой харьцааны журмын дагуу хөрөнгө оруулалт, төслийн зээл олгох, валют худалдах, худалдан авах;

6.8.4. Хорооноос тогтоосон журам, зөвшөөрлийн дагуу мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулалтын сангийн зөвшөөрөгдсөн активт байршуулах болон баталгаажсан үнэт цаас худалдах, худалдан авах;

6.8.5. хууль журмаар зөвшөөрсөн авлага худалдах, худалдан авах, факторингийн үйлчилгээ үзүүлэх;

6.8.6. актив хөрөнгийн багцыг үр ашигтай, өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгсэл болгох зөвлөгөө өгөх, тооцоо судалгаа, мэдээллээр хангах;

6.8.7. хөрөнгө (актив)-ийн чанарыг сайжруулах, үнэ цэнэ хүргэх зорилгоор анхны хөрөнгө эзэмшигчийн хувьцааг эзэмших замаар өөрийн хөрөнгийг санхүүжүүлэх, дахин хөрөнгөжүүлэх, бүтцийн санхүүжилт хийх, хөрөнгийг хуваах, салгах, нийлүүлэх;

6.8.8. Хуулиар хориглоогүй, Хорооноос зөвшөөрсөн бусад үйл ажиллагаа.

ДОЛОО. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ОЛГОХООС ТАТГАЛЗАХ

7.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн этгээд нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягт СЗХ02001-ийн дагуу гаргасан өргөдөл, 2 дугаар хавсралт (А)-д заасан хавсаргах баримт бичгийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 8, 9, 10 дугаар зүйлд заасны дагуу бүрдүүлж Хороонд хэвлэмлээр, эсхүл цахимаар ирүүлнэ.

7.2. ББСБ нь тусгай зөвшөөрлийн төрөл, үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөх, цуцлах тохиолдолд энэ журмын 7.1-д заасны дагуу Хороонд дахин хандах бөгөөд зөвхөн нэмж, эсхүл өөрчилж буй үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, баримт бичгийг ирүүлэх ба өмнөх ангиллын тусгай зөвшөөрөл авахтай холбоотой ирүүлсэн баримт бичигт өөрчлөлт орохооргүй бол дахин бүрдүүлж өгөх шаардлагагүй.

7.3. Хорооны тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-т заасны дагуу хянаж, бүрдлийг шалгаж хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор Хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

7.4. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шийдвэрт тухайн хуулийн этгээдийн эрхлэх банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн төрөл, төрөл чиглэлийн хүрээнд эрхлэх үйл ажиллагаанууд, тэдгээрийг дагнан эсхүл хавсран эрхлэх талаар тодорхой тусгана.

7.5. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгож, нэгдсэн бүртгэлд бүртгэн, зохих зааврын дагуу хувийн хэрэг нээн хөтөлнө.

7.6. ББСБ нь тусгай зөвшөөрлийн төрөл үйл ажиллагааны чиглэлээ өөрчилсөн тохиолдолд Хорооны шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинэчилж, гэрчилгээний хавсралтад өөрчлөлт оруулж, тэмдэглэгээ хийлгэнэ.

7.7. Хорооны шийдвэрийг үндэслэн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлж, тамга тэмдэг авснаар үйл ажиллагаа эхлүүлсэнд тооцно.

7.8. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлж нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээний болон дүрмийн хуулбар эсхүл, эх хувийг Хороонд ирүүлнэ.

7.9. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичиг нь шаардлага хангаагүй эсхүл дараах үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана. Үүнд:

7.9.1. хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг зээлийн эх үүсвэрээр бүрдүүлсэн нь нотлогдсон;

7.9.2. банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон;

7.9.3. хувьцаа эзэмшигч /хувьцаа эзэмшигчид/ нь зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн, хугацаа хэтэрсэн аливаа өртэй;

7.9.4. хувьцаа эзэмшигч /хувьцаа эзэмшигчид/, эрх бүхий албан тушаалтнууд нь гэмт хэрэгт шалгагдаж байгаа болон шүүхийн шийтгэх тогтоолоор ял шийтгэл эдэлж байгаа нь тогтоогдсон;

7.9.5. Өргөдлийн мэдээллээр бүрдүүлсэн баримт бичигтэй холбоотойгоор нэмж тодруулах зайлшгүй шаардлагатай зүйл гарвал Хороо энэ талаар албан бичгээр мэдэгдэж, нэмэлт мэдээлэл, материал авч болно;

7.9.6. энэхүү журамд заасан бусад нөхцөл, шаардлагыг хангаагүй.

7.10. Өргөдлийн мэдээлэл, бүрдүүлсэн баримт бичигтэй холбоотойгоор нэмж тодруулах зайлшгүй шаардлагатай гэж үзвэл Хороо энэ талаар албан бичгээр мэдэгдэж, нэмэлт мэдээлэл, баримт бичиг авч болно.

7.11. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

7.12. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн гэдэг үндэслэлээр татгалзсан өдрөөс хойш тухайн хүсэлт гаргагч хуулийн этгээдээс банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг 1 жилийн дотор дахин хүлээн авахгүй.

НАЙМ. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ НЭМЖ ОЛГОХ, ОЛГОХООС ТАТГАЛЗАХ

8.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн төрөл чиглэлийн хүрээнд тусгай зөвшөөрөл анх авахдаа хүсэлт гаргаагүй, энэ зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа нэмж эрхлэх зөвшөөрөл хүссэн ББСБ нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан тусгай зөвшөөрлийн маягт СЗХ02002-ын дагуу өргөдөл гаргах бөгөөд 2 дугаар хавсралт (Б)-д заасан баримт бичгийг хавсарган Хороонд хэвлэмэл, эсхүл цахимаар ирүүлнэ.

8.2. Хороо нь энэ журмын дагуу тусгай зөвшөөрлийн төрөл чиглэл бүрт тавигдсан нөхцөл, шаардлагыг хангасан ББСБ-д нэмж эрхлэх үйл ажиллагааны зөвшөөрлийг олгоно.

8.3. ББСБ-аас ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-т заасны дагуу хянаж, хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор Хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

8.4. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нэмж олгох тухай Хорооны шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, баталгаажуулсны дараа ББСБ нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт холбогдох бүртгэлийг хийлгэнэ.

8.5. ББСБ нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлсэн шинэчилсэн буюу өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг ирүүлнэ.

8.6. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрлийг нэмж эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд энэ талаар гарсан Хорооны шийдвэрийг шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор хүсэлт гаргагч ББСБ-д албан бичгээр хүргүүлнэ.

8.7. Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагааны зөвшөөрөл нэмж олгохоос татгалзсан тохиолдолд нөхцөл шаардлага хангасны дараа тухайн ББСБ-аас банк бус санхүүгийн үйл ажиллагааны зөвшөөрөл нэмж эрхлэх хүсэлтийг дахин энэ журмын дагуу гаргаж болно.

ЕС. БУСАД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ОЛГОХООС ТАТГАЛЗАХ

9.1. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн:

9.1.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14.5-д заасны дагуу ББСБ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай бүр аливаа гүйлгээ хийгдэхээс өмнө зөвшөөрөл авна.

9.1.2. зөвшөөрөл хүссэн ББСБ нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан өргөдлийн маягт СЗХ02002-ын дагуу өргөдөл гаргах ба 2 дугаар хавсралт (В)-д заасан баримт бичгийг хавсаргаж Хороонд хэвлэмэл, эсхүл цахимаар ирүүлнэ.

9.1.3. ББСБ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнийг дараах тохиолдолд өөрчилж болно. Үүнд:

9.1.3.1. ББСБ-ын тайлант жилийн ашгаас хуваарилагдсан ногдол ашгаар нэмэгдүүлэх;

9.1.3.2. хувьцаа эзэмшигчид нэмэлт хөрөнгө оруулах;

9.1.3.3. шинээр хувьцаа гаргах;

9.1.3.4. хувьцаа эзэмшигчээс оруулсан хувьцааг зөвхөн гэр бүлийн гишүүдийн хүрээнд Иргэний хуульд заасны дагуу өвлүүлэх, бэлэглэх, өөр хоорондоо болон гуравдагч этгээдэд худалдах;

9.1.3.5. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангах боломжтой, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулснаар бусад хувьцаа эзэмшигч, харилцагчдад хохирол учруулахгүй бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хорогдуулах.

9.1.4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл хүсч ББСБ-аас ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-т заасны дагуу хянаж, хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Хорооны дарга шийдвэрлэнэ.

9.1.5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, баталгаажуулсны дараа ББСБ нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт холбогдох бүртгэлийг хийлгэнэ.

9.1.6. ББСБ нь өөрчлөлт орсон улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, эсхүл эх хувийг Хороонд ирүүлнэ.

9.1.7. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор мөнгөн хөрөнгийг хууль ёсны үйл ажиллагаанаас олсон болох нь нотлогдохгүй, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцэд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн эрх бүхий этгээдийн шийдвэр болон гэрээ хэлцэл нь хуурамч тохиолдолд зөвшөөрөл олгохоос татгалзана.

9.1.8. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

9.2. Хоёрдогч өглөгийн зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах:

9.2.1. Хоёрдогч өглөгийн зөвшөөрөл хүссэн ББСБ нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягт СЗХ02002-ийн дагуу гаргасан өргөдөл, 2 дугаар хавсралт (Г)-д заасан баримт бичгийг хавсаргаж Хороонд хэвлэмэл, эсхүл цахимаар ирүүлнэ.

9.2.2. ББСБ-аас ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-т заасны дагуу хянаж, хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Хорооны дарга шийдвэрлэнэ.

9.2.3. Хоёрдогч өглөгийн гэрээнд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаанд хөрвөх нөхцөлийг тусгасан байна.

9.2.4. Хоёрдогч өглөгийн үндсэн өрийг ББСБ-ыг татан буугдсан, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, дампуурсан, төлбөрийн чадваргүй болсныг зарласан, өөрчлөн байгуулснаас бусад тохиолдолд хугацаанаас нь өмнө барагдуулахыг хориглоно.

9.2.5. Хороо ББСБ-аас ирүүлсэн энэхүү журмын 9.2.1-д дурдсан баримт бичгүүд нь зохих нөхцөл, шаардлагыг хангаагүй үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана.

9.2.6. Хоёрдогч өглөг татах зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд үндэслэл бүхий тайлбарыг хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

9.3. Нэгж байгуулах зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, хүчингүй болгох:

9.3.1. Нэгж байгуулах зөвшөөрөл хүссэн ББСБ нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягт СЗХ02002-ын дагуу гаргасан өргөдөл, 2 дугаар хавсралт (Д)-д заасан баримт бичгийг хавсаргаж, Хороонд хэвлэмэл, эсхүл цахимаар ирүүлнэ.

9.3.2. ББСБ-ын салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй, тухайн ББСБ-ын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах ба зөвхөн тухайн компанийн оноосон нэрийг хэрэглэнэ.

9.3.3. ББСБ-ын оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний эрхлэх тусгай зөвшөөрөлтэй банк бус санхүүгийн үйл ажиллагааг эрхэлж буй нэгжийг салбар гэнэ.

9.3.4. ББСБ-ын оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах буюу түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий нэгжийг төлөөлөгчийн газар гэнэ.

9.3.5. Салбар, төлөөлөгчийн газар нь Хорооноос олгогдсон зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэх ба нэгж тус бүр нь зөвшөөрлийн гэрчилгээтэй байна.

9.3.6. ББСБ-аас нэгж байгуулахаар хүсч ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-т заасны дагуу хянаж, нэгж байгуулах нь тухайн ББСБ-ын санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, боловсон хүчин, техник тоног төхөөрөмж, програм хангамж нь тухайн нэгжийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл, шаардлагыг хангасан гэж үзвэл 14 хоногийн дотор Хорооны дарга шийдвэрлэнэ.

9.3.7. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад холбогдох тэмдэглэгээг хийж, нэгжийн гэрчилгээг олгож, баталгаажуулсны дараа ББСБ нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт холбогдох бүртгэлийг хийлгэнэ.

9.3.8. ББСБ нь өөрчлөлт орсон улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, эсхүл эх хувийг Хороонд ирүүлнэ.

9.3.9. ББСБ нь салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах, өөрчлөн байгуулах шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор Хороонд албан бичгээр мэдэгдэнэ.

9.3.10. Хороо дараах үндэслэлээр ББСБ-ын салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрөл олгохоос татгалзаж, энэ тухай тайлбарыг хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ. Үүнд:

9.3.10.1. Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар хангалтгүй болон муу үнэлгээ авсан, шалгалтын дүнгээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй;

9.3.10.2. Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сүүлийн 2 улирал дараалан хангаж ажиллаагүй;

9.3.10.3. нэгжийн зөвшөөрөл хүч ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь нотлогдсон;

9.3.10.4. энэхүү журамд заасан бусад нөхцөл, шаардлагыг хангаагүй.

9.3.11. ББСБ-ын салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийг шинээр олгохоос татгалзсан тохиолдолд нөхцөл шаардлага хангасны дараа ББСБ-аас салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрөл нэмж хүссэн өргөдлийг Хороонд дахин ирүүлж болно.

9.3.12. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн үндэслэлээр салбар, төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл олгохоос Хороо татгалзсан тохиолдолд уг өдрөөс хойш 1 жилийн хугацаанд дахин зөвшөөрөл хүссэн өргөдлийг Хороо хүлээн авахгүй.

9.3.13. Нэгжийн зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож зөвшөөрлийн гэрчилгээг хураан авна. Үүнд:

9.3.13.1. нэгжийг татан буулгах ББСБ-ын удирдлагын шийдвэр;

9.3.13.2. холбогдох хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй болон нэгжийн үйл ажиллагаа нь тухайн ББСБ-ын хэвийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварт хүндрэл учруулахаар байгааг тогтоосны үндсэн дээр гаргасан Хорооны даргын шийдвэр.

9.3.14. ББСБ-ын салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах болон банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай Хорооны шийдвэр нь салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно.

9.4. Оноосон нэр өөрчлөх зөвшөөрөл олгох:

9.4.1. Оноосон нэр өөрчлөх зөвшөөрөл хүссэн ББСБ нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягт СЗХ02002-ын дагуу гаргасан өргөдөл, 2 дугаар хавсралт (Е)-д заасан баримт бичгийг хавсаргаж, Хороонд хэвлэмэл, эсхүл цахимаар ирүүлнэ.

9.4.2. Оноосон нэр солих өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-т заасны дагуу хянаж, оноосон нэрийг өөрчлөх нь ББСБ-ын харилцагчдад сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй гэж үзвэл 14 хоногийн дотор Хорооны дарга шийдвэрлэнэ.

9.4.3. ББСБ-ын оноосон нэр өөрчлөхийг зөвшөөрсөн шийдвэр гарсны дараа Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан хураамжийг төлсөн баримтыг үндэслэн Хороо холбогдох тэмдэглэгээг хийж баталгаажуулсан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинэчлэн олгосны дараа ББСБ нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт холбогдох бүртгэлийг хийлгэнэ.

9.4.4. ББСБ нь өөрчлөлт орсон улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, эсхүл эх хувийг Хороонд ирүүлнэ.

АРАВ. ХҮСЭЛТИЙГ БҮРТГЭХ, БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗАХ

10.1. Гүйцэтгэх удирдлага өөрчлөгдсөнийг бүртгэх тохиолдолд дараах зарчмыг баримтална. Үүнд:

10.1.1. ББСБ-ын гүйцэтгэх удирдлага өөрчлөгдсөн тохиолдолд энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягт СЗХ02003-ын дагуу гаргасан өргөдөл, 2 дугаар хавсралт(Ё)-д заасан хавсаргах баримт бичгийг бүрдүүлж Хороонд хэвлэмэл эсхүл цахимаар ирүүлнэ.

10.1.2. Гүйцэтгэх захирлыг өөрчилсөнтэй холбоотой ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан "Зөвшөөрлийн өргөдөл, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар"-т заасны дагуу хянаж үзээд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.5,13.6-д заасан шалгуурыг хангасан гэж үзвэл 5 хоногийн дотор Хорооны мэдээллийн нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

АРВАН НЭГ. БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

11.1. Хороо нь энэ журмын 1.3-т заасан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, түүний хүрээнд олгосон нэмэлт зөвшөөрлийг дараах үндэслэлээр 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ. Үүнд:

11.1.1. Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллаагүй нь санхүү төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх болзошгүй болсон;

11.1.2. Хорооноос тогтоосон журмыг зөрчиж, санхүүгийн тайлан, мэдээг хугацаанд нь удаа дараалан ирүүлээгүй, хяналт, шалгалт хийх боломжгүй болгосон;

11.1.3. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаж ажиллаагүй;

11.1.4. Хорооноос хийсэн зайны хяналт шалгалтаар “Их эрсдэлтэй” гэж үнэдэгдсэн газар дээрх шалгалтаар хангалтгүй үнэлгээ авсан;

11.1.5. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

11.2. Энэ журмын 11.1-д заасан үндэслэлээр банк бус санхүүгийн тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх үйл ажиллагааг түдгэлзүүлсэн тохиолдолд түдгэлзүүлсэн үндэслэл болсон зөрчил дутагдлыг арилгаж хэвийн үйл ажиллагаагаа хангасан тохиолдолд тухайн ББСБ-ын хүсэлтийг үндэслэн сэргээж болно.

11.3. Тусгай зөвшөөрлөө сэргээлгэх хүсэлтэй ББСБ-нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан тусгай зөвшөөрлийн маягт СЗХ02002-ын дагуу гаргасан өргөдлөө Хороонд ирүүлнэ.

11.4. Хороо нь энэ журмын 1.3-т заасан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно. Үүнд:

11.4.1. ББСБ өөрөө хүсэлт гаргасан;

11.4.2. Хорооноос баталж гаргасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн шаардлагыг удаа дараа хангаагүй, санхүү, төлбөрийн чадваргүй болсон

11.4.3. дампуурсан эсхүл татан буугдсан тухай эрх бүхий байгууллага, хувьцаа эзэмшигчдийн хурлаас зарласан;

11.4.4. тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн тогтоогдсон нь харилцагчид ноцтой хохирол учруулах болсон;

11.4.5. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

11.4.6. Хорооноос хийсэн зайны хяналт шалгалтаар “Их эрсдэлтэй” гэж үнэдэгдсэн газар дээрх шалгалтаар хангалтгүй үнэлгээ авсан;

11.4.7. ирүүлбэл зохих санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь удаа дараалан ирүүлээгүй, хяналт, шалгалт хийх боломжгүй болгосон 9 сар дараалан Хороонд ирүүлээгүй;

11.4.8. Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг Хороонд ирүүлээгүй;

11.4.9. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

11.5. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд Хороо энэ тухай олон нийтэд мэдээлэн, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, хүчингүй тэмдэг даран, тухайн ББСБ-ын хувийн хэрэгт хийж, зохих журмын дагуу архивт шилжүүлнэ.

11.6. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос учирсан аливаа хохирлыг Хороо хариуцахгүй.

11.7. Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх үйл ажиллагааг түдгэлзүүлсэн шийдвэр гаргасан өдрөөс хойш ББСБ нь дараах үйлдэл хийхийг хориглоно. Үүнд:

11.7.1. шинээр аливаа гэрээ, хэлцэл байгуулах;

11.7.2. тухайн өдрөөс өмнө байгуулсан аливаа гэрээ, хэлцэлд нэмэлт өөрчлөлт оруулах.

11.8. Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэр гаргасанаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа нь дуусгавар болно.

11.9. Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон шийдвэр гаргасан өдрөөс хойш тэдгээр үйл ажиллагааг үргэлжлүүлбэл тусгай зөвшөөрөлгүйгээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэж холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

АРВАН ХОЁР. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

12.1. Холбогдох хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, заавар, шийдвэрийн биелэлт болон санхүүгийн үйл ажиллагаанд Хороо хяналт тавьж, шалгалт хийнэ.

12.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны 20 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----oO----

**БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ,
ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛИЙН МАЯГТ БӨГЛӨХ, БАРИМТ БИЧГИЙГ
БҮРДҮҮЛЭХ ЗААВАР**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү зааврын зорилго нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягтыг бөглөх, тэдгээрт хавсаргах баримт бичгийг бүрдүүлэхэд банк бус санхүүгийн байгууллага /цаашид ББСБ гэх/, тэдгээрийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, удирдлагуудад мөрдлөг болгон ашиглахад оршино.

**ХОЁР. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН МАЯГТ БӨГЛӨХ,
БАРИМТ БИЧИГ БҮРДҮҮЛЭХ**

А.Тусгай зөвшөөрлийн СЗХ02001 маягтыг бөглөх заавар

Үүсгэн байгуулагч нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдээ улсын бүртгэлд бүртгүүлсний дараа банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/-нд хандана.

Тусгай зөвшөөрлийн өргөдлийн маягтыг Хорооны вэбсайт дахь "online" өргөдлийн маягт цонхонд хандаж цахимаар бөглөнө. Өргөдлийн маягтыг цаасаар бөглөх тохиолдолд Хорооны вэбсайтаас татаж авна.

Маягтыг бөглөхдөө техникийн үзүүлэлт, компанийн хэлбэрээс бусад тохиолдолд товчлол хэрэглэхгүй, иргэний овог нэр, оноосон нэр, он сар өдрийг бүтэн бичиж, сонгох тохиолдолд тохирох нүдэнд "✓" тэмдгийг тавина.

Хэсэг 1. Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл

1. Өргөдөл гаргасан огноо: Он, сар, өдөр гэсэн дарааллаар тоогоор бичнэ.
2. Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн нэр: Үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн оноосон нэрийг бичнэ.
3. Өмнө нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байсан бол тийм гэсэн сонголт, явуулж байгаагүй бол үгүй гэсэн сонголтыг хийнэ.
4. Бизнесийн аль салбарт, ямар чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан тухайгаа товч бичнэ.
5. Өмнө нь тусгай зөвшөөрөл хүсч ирүүлж байсан бол тийм гэсэн сонголт, ирүүлж байгаагүй бол үгүй гэсэн сонголтыг хийнэ.
6. Тусгай зөвшөөрөл хүсч байсан бол хэдэн онд, Хорооноос ямар шалтгаанаар татгалзсан тухай товч бичнэ.

7. Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны төрлийг сонгохдоо: Валютын арилжааны ББСБбол 1 дэх багана, Зээл, санхүүжилтийн ББСБ бол 2 дахь баганаас эрхлэх үйл ажиллагааны төрлөө сонгоно.
8. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагдсан огноо, хуулийн этгээдийн хэлбэр, хөрөнгө оруулалтын хэлбэр, хаяг байршил, цахим хаяг зэрэг үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг асуулгын дагуу нөхнө.
9. Шинээр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн дансны мэдээллийг оруулахдаа дансны төрлийг сонгож, банкны нэр, дансны дугаар, валютын төрөл бүрээр банкин дахь харилцах, хадгаламжийн дансны үлдэгдлийг нөхнө.
10. *Тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээллийг бөглөхдөө:* Хуулийн этгээд, иргэнээс оруулсан хувь хөрөнгийн хэмжээг хувьцааны тоо, хэмжээ, хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь тус бүрээр хүснэгт дэх асуулгын дагуу нөхнө. Хувь нийлүүлсэн хөрөнгө нь Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээг хангасан байх бөгөөд хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдсэн байна.

Хэсэг 2. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулагч нь хуулийн этгээд, иргэний аль нь болохыг тодорхойлж, тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина.

1. Үүсгэн байгуулагч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн талаарх мэдээлэл:

- 1.1. Оноосон нэр: Монгол – хуулийн этгээдийн нэрийг кирилл үсгээр, бүтэн бичнэ.
Англи – хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ.
- 1.2. Хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан огноог он, сар, өдөр гэсэн дарааллаар бичнэ.
- 1.3. Хуулийн этгээдийн хэлбэр: ХК-Хувьцаат компани, ХХК-Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нь болохыг сонгоно.
- 1.4. Хөрөнгө оруулалтын хэлбэрээс тохирох нүдийг сонгоно. Гадаадын хөрөнгө оруулалттай компани гэдэгт нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 мянган ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуй нэгжийг ойлгоно.
- 1.5. Бизнесийн салбар, үйл ажиллагааны чиглэл: Үүсгэн байгуулагч хуулийн этгээд нь бизнесийн аль салбарт, ямар чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг болохоо бичнэ.
- 1.6. Үйл ажиллагааны орлого, ашиг: Санхүүгийн тайлангаарх орлого, зардал, татвар төлсний дараах цэвэр ашгийн дүнг төгрөгөөр бичнэ.
- 1.7. Хуулийн этгээдэд оруулах хувь нийлүүлсэн хөрөнгө: Үүсгэн байгуулагч хуулийн этгээдээс оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг төгрөгөөр бичнэ.
- 1.8. Хаяг байршил: Хуулийн этгээдийн одоо байршиж байгаа эсхүл байршихаар гэрээ байгуулсан байрны хаягийг хүснэгт дэх асуулгын дагуу дэлгэрэнгүй бичих бөгөөд хаяг байршилыг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлсэн байна.

1.9. Холбоо барих утас: Хуулийн этгээдийн холбоо барих суурин, гар утас, факсны дугаарыг бичнэ.

1.10. Цахим хаяг, цахим хуудас: Хуулийн этгээдийн албан ёсны цахим хаяг, хуудсыг бичнэ./Цахим хуудасгүй бол бөглөх шаардлагагүй/.

Үүсгэн байгуулагч хуулийн этгээдийн компанийн нэгдлийн талаарх мэдээллийг бөглөхдөө:

1.11. Компанийн нэгдэлд хамрагддаг эсэхийг тодорхойлж, тийм, үгүй гэсэн сонголтоос тохирох нүдийг сонгоно.

1.12. Нэгдэлд оролцогч компаниудын оноосон нэр: Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх хуулийн этгээдийн нэр /гадаадын хуулийн этгээд бол тухайн гадаад улсын зохих байгууллагаас олгосон гэрчилгээн дэх нэр/-ийг бичнэ.

1.13. Компанийн хэлбэр: Хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нь болохыг сонгоно.

1.14. Тусгай зөвшөөрөл хүсэгч компанитай ямар холбоотой болох талаар толгой, хараат, охин, зэргэлдээ гэсэн нүднээс сонгоно.

1.15. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагдсан огноог он, сар, өдөр гэсэн дарааллаар бичнэ.

1.16. Нэгдэлд оролцогч компаниудын эрхэлж буй үйл ажиллагааны төрлийг бичнэ.

1.17. Байгууллагын хаяг, утас, цахим хуудас/цахим хуудасгүй бол бөглөх шаардлагагүй/, цахим шуудангийн хаяг зэрэг мэдээллийг хүснэгтэд оруулна.

2. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь иргэн бол тэдгээрийн талаарх мэдээлэл:

2.1. Иргэний овог нэр, регистрийн дугаар, засаг захиргааны бүртгэлтэй албан ёсны хаяг байршил, ажил эрхлэлт, мэргэжлийн талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу бичнэ.

Үүсгэн байгуулагч иргэн бүрээр хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээллийг бөглөхдөө:

2.2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг төгрөгөөр, харилцах, хадгаламжийн дансны үлдэгдлийг тухайн валютаар нь өргөдөл гаргах өдрийн үлдэгдлээр бичнэ.

Хэсэг 3. Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл

Тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн удирдлага, боловсон хүчинтэй холбоотой мэдээллийг бөглөхдөө:

1. Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, дотоод хяналтын нэгжтэй эсэх талаар хариултыг сонгон, тэдгээрийн бүрэлдэхүүний тоог бичнэ.
2. Ажилтан, албан хаагчдын тоо хэсэгт хуулийн этгээдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах болон ажиллаж буй нийт ажилтны тоог бичнэ.
3. Удирдах албан тушаалтнуудын талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу гаргах бөгөөд удирдах албан тушаалтан нь гадаадын иргэн тохиолдолд регистрийн дугаар хэсэгт гадаад паспортын дугаарыг бичнэ.

Тайлбар: Удирдах албан тушаалтан гэдэгт гүйцэтгэх удирдлага, хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагаанд оролцон ажиллах /ажилладаг/ ажилтнуудын мэдээллийг хүснэгт дэх

асуулгын дагуу нөхөж, тодорхойлолтыг зааврын хавсралтын дагуу гаргах бөгөөд тодорхойлолт гаргасан этгээд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Жич: Хавсралтад сүүлийн 1 жилийн хугацаанд авахуулсан 3*4 хэмжээтэй цээж зургийг наана.

Хэсэг 4. Үйл ажиллагаа явуулах ажлын байрны мэдээлэл

1. Ажлын байр хэсэгт тухайн ажлын байрыг худалдаж авсан, түрээсэлсэн аль нь болохыг бичих бөгөөд энэ нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх хаяг байршил, дүрэмд тусгагдсан хаяг байршилтай ижил байна.

Хэсэг 5. Ашиглах техник тоног төхөөрөмж, програм хангамжийн мэдээлэл

2. Үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжийг нэр, төрөл бүрээр түүний хүчин чадал, багтаамж, тоо ширхэг, үнийн талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу бөглөх ба тухайн тоног төхөөрөмжийг худалдаж авсан түрээсэлсэн аль нь болохыг тодорхой бичнэ. Тоног төхөөрөмжийн үнэ нь худалдан авсан өртөг байна.
3. Програм хангамжийн зориулалт баганад тухайн програмыг ямар зориулалтаар ашиглах талаар бичнэ. Жишээ нь нягтлан бодох бүртгэл, зээлийн мэдээллийн санд мэдээ өгч, авах, өдөр тутмын мэдээ, мэдээлэл боловсруулах гэх мэт.
4. Хөрөнгийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах үүднээс ажлын байрны харуул хамгаалалтын асуудлыг шийдвэрлэж, холбогдох этгээдтэй гэрээ байгуулсан байна.

Хэсэг 6. Тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх үйл ажиллагааны төлөвлөлт

Тухайн үйл ажиллагааг ямар хүрээнд явуулах, эх үүсвэрийн өртөг, хүлээгдэж буй ашиг, тухайн үйл ажиллагаанаас хүртэх өгөөжийн хэмжээг зэрэгцүүлсэн он, хүснэгтэд заасан үзүүлэлт бүрээр тоон үзүүлэлтийг өссөн дүнгээр бичих бөгөөд энэ нь бизнес төлөвлөгөөнд тусгагдсан дүнтэй ижил байна.

Бизнес төлөвлөгөө боловсруулах зөвлөмж

Бизнес төлөвлөгөөг 3-аас доошгүй жилийн хугацаатай боловсруулах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байна. Бизнес төлөвлөгөө нь эмх цэгцтэй, ойлгомжтой, бүлэг хэсгүүд нь уялдаа бүхий мэдээлэл нь цаг хугацаандаа, үнэн бодитой, үр дүн нь хэмжигдэхүйц байвал зохино. Бизнес төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгасан байна.

1. Компанийн танилцуулга
 - Компанийн түүх
 - Одоогийн явуулж буй үйл ажиллагаа
 - Хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшилт
 - Бүтэц зохион байгуулалт, удирдлага, хүний нөөц
2. Зах зээлийн судалгаа
 - Зах зээл, хэрэглэгч, зах зээлийн ерөнхий чиг хандлага
 - Бизнесийн хууль эрх зүйн орчин
 - Өрсөлдөөн, өрсөлдөгчид
 - Бизнес төлөвлөгөө бичих болсон үндэслэлүүд

3. Төлөвлөсөн бизнесийн үйл ажиллагаа

- Бүтээгдэхүүн, үйл ажиллагааны төлөвлөгөө
- Маркетингийн төлөвлөгөө
- Менежментийн төлөвлөгөө
- Санхүүгийн төлөвлөгөө
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө
- Эрсдлийн менежмент /бууруулах арга зам

4. Санхүүгийн шинжилгээ

1. Компанийн танилцуулга

*1.1. Компанийн түүх:*Энэ хэсэгт танай компани анх хэдэн онд байгуулагдсан, ямар бизнес эрхэлж байсан, компанийн түүх, ололт амжилтын талаар дурьдахаас гадна одоогийн явуулж буй үйл ажиллагаа, бизнесийн чиглэл, бүтээгдэхүүн үйлчилгээ, бүтэц бүрэлдэхүүний талаар бичнэ /Өмнө нь үйл ажиллагаа явуулж байгаагүй бол бичих шаардлагагүй/.

1.2. Одоогийн явуулж буй үйл ажиллагаа: Хуулийн этгээд бизнесийн аль салбарт ямар чиглэлээр бүтээгдэхүүн үйлчилгээ эрхэлдэг, одоогийн бизнесийн орчин, эзэмшиж буй тоног төхөөрөмж, барилга байгууламж, хөрөнгө оруулалтын хэмжээ, бүтээгдэхүүн үйлчилгээний тоо хэмжээ, нийлүүлэгч, хамтран ажилладаг байгууллага, харилцагчдын талаарх мэдээллийг бичнэ. /Өмнө нь үйл ажиллагаа явуулж байгаагүй бол бичих шаардлагагүй/

1.3 Хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшилт: Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгийн талаар дэлгэрэнгүй бичнэ.

*1.4 Бүтэц зохион байгуулалт, удирдлага, хүний нөөц:*Энэ хэсэгт тухайн байгууллагын боловсон хүчний бүтэц, зохион байгуулалт, удирдлагын багийн танилцуулга, тэдний өмнө хийж байсан ажил, ажлын туршлага, одоогийн хариуцан ажилладаг ажлын талаар танилцуулна. Тухайн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг схемчлэн зурж болно.Боловсон хүчний талаар одоо компанид нийт хэдэн хүн ажиллах, тэднээс хэд нь үндсэн ажилчин, хэд нь гэрээт ажилчин байх, тэдгээрийн цалин хөлс, ямар чиглэлийн ажил хариуцдаг, ажилчид дотроо газар, хэлтэс, салбар зэрэгт хуваагддаг эсэх талаар бичнэ. Цаашид ажилчдын тоог нэмэгдүүлэх эсэх талаар тодруулна.

2. Зах зээлийн судалгаа

Зах зээлийн байдал, хэрэглэгчид, зах зээлд гарч байгаа ерөнхий чиг хандлага, тухайн бизнесийн хууль эрх зүйн орчин, тухайн салбар дахь өрсөлдөгчдийн талаар мэдээллүүдийг багтаана.

2.1. Зах зээл, хэрэглэгч, зах зээлийн ерөнхий чиг хандлага: Энэ хэсэгт зах зээлийн хэмжээ, хэрэглэгчдийн тоо хэмжээ, тухайн хуулийн этгээдийн зах зээлд эзлэх хувь, зах зээлийн өсөлт, ирээдүйн зах зээлийн байдал, зах зээлийн тогтвортой байдал, зах зээлд гарч байгаа ерөнхий чиг хандлагуудыг бичих бөгөөд технологийн хөгжил, байгалийн хүчин зүйлс, хүн амын суурьшилт зэргийг тодруулна.

*2.2. Бизнесийн хууль эрх зүйн орчин:*Тухайн бизнесийг эрхлэхтэй холбоотой хуулиудыг судалсан эсэх, шаардагдах бичиг баримтыг бүрдүүлж баталгаажуулсан эсэх, хууль эрх зүйн орчинд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах арга замыг тодорхой бичнэ.

*2.3. Өрсөлдөөн, өрсөлдөгчид:*Тухайн зах зээл дээрх ижил төрлийн бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо хэмжээ, нэр, байршил, хүчин чадал, зах зээлд эзлэх хувь, давуу

болон сул талуудын талаар дурьдана. Компанийн дотоод, гадаад хүчин зүйлсийг судалсан SWOT шинжилгээг хийсэн байвал зохино.

Өрсөлдөгчийн нэр	Байршил	Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл	Багцын хэмжээ	Бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ, хүүгийн хэмжээ	Зах зээлд эзлэх байр суурь
Өрсөлдөгч 1					
Өрсөлдөгч 2					
Өөрийнх					

2.4. *Бизнес төлөвлөгөө бичих болсон үндэслэлүүд*: Яагаад шинээр үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгааныг бичиж, зах зээл, өөрийн хүчин чадлын хэмжээг харгалзан тухайн бизнесийг өргөжүүлэх нөөц, боломжийг тодруулна.

3. Төлөвлөсөн бизнесийн үйл ажиллагаа:

3.1 *Бүтээгдэхүүн үйл ажиллагааны төлөвлөгөө*: Үйл ажиллагаа эрхлэн явуулснаар тухайн бүтээгдэхүүн үйлчилгээг ямар хэмжээгээр хүргэх, харилцагч, үйлчлүүлэгчдийн цар хүрээг тодорхойлж, тооцооллыг хийнэ.

3.2. *Маркетингийн төлөвлөгөө*: Өмнөх бүлэгт хийсэн зах зээл, хэрэглэгчдийн судалгааг үндэслэн боловсруулна. Үүнд зах зээлээ сонгох, бүтээгдэхүүн үйлчилгээг идэвхжүүлэх үйл ажиллагаа орно. Маркетингийн төлөвлөгөө нь маркетингийн иж бүрдлээс бүрдэнэ. Үүнд: бүтээгдэхүүн (үйлчилгээ), үнэ (үнийг хэрхэн тогтоох), байрлал (суваг, хуваарилалт), идэвхжүүлэлт (зар сурталчилгаа) зэргийг хэрхэн шийдвэрлэсэнээ тодорхойлно.

3.3. *Менежментийн төлөвлөгөө*: Байгууллагын удирдлага, бүтэц, зохион байгуулалт, удирдах ажилтан бүрийн хариуцлага, ажилчдын нэрс, цалингийн зардлыг тодорхой бичиж, боловсон хүчнийг бэлтгэх, чадваржуулах шаардлага, тэдгээрт хийх сургалтын талаар тодруулна.

3.4. *Санхүүгийн төлөвлөгөө*: Санхүүгийн төлөвлөгөөнд бизнесийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, орлого, зардал, ашиг, алдагдлыг тооцож, түүнийг хэрхэн удирдах талаар тусгана.

Орлогыг тооцохдоо тухайн орлогыг бүрдүүлэх эх үүсвэр бүрээр тооцож нэгтгэн гаргана.

Зардлыг тооцохдоо бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбогдон гарах, удирдлага зохион байгуулалттай холбоотой, эх үүсвэр татах / зээл, хүү/, албан татвар хураамж төлөх, хөрөнгө оруулалттай холбогдон гарах болон бусад зардал гэх мэтчилэн зардлын зүйл анги бүрээр тооцож, нэгтгэн гаргана.

Мөнгөн урсгалыг тооцохдоо сар бүрийн орж, гарах мөнгөн урсгалыг тооцож, жилээр нэгтгэн гаргана.

Санхүүгийн тайлан баланс зэрэг тоон үзүүлэлтийг бизнес төлөвлөгөөнд тусгахдаа өмнөх онуудын гүйцэтгэлийг ирэх жилийн төлөвлөгөөтэй зэрэгцүүлсэн байдлаар гаргана.

3.5. *Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө*: Шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаа, үүнээс өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс оруулж чадах хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгө оруулалтыг хаанаас авахаар төлөвлөж байгаа /банкны зээл, гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын байгууллагын тусламж, гадаадын банкнаас авах зээл, хувь нийлүүлэгчдийн хөрөнгө оруулалт/-ын талаар бичнэ. Хэрэв өглөг, авлагатай бол энэ талаар жагсаалт үйлдэж, нарийвчлан тодруулсан байна.

3.6. *Эрсдэлийн менежмент бууруулах арга зам:* Бизнес эрхлэхэд олон төрлийн эрсдэл учирч болох бөгөөд техник, санхүү, байгалийнгамшиг, хууль эрх зүй, улс төрийн эрсдэлийг зайлшгүй тооцож өөрийн бизнесийн онцлогт уялдуулан бичнэ. Мөн таны бизнест ямар төрлийн эрсдэл учрах магадлал өндөр болохыг тодорхойлж, эрсдлийгдоод хэмжээнд байлгах, түүнээс сэргийлэх, бууруулахын тулд та ямар арга хэмжээ төлөвлөснөө бичихнь зүйтэй. Мөн даатгалд хамруулж болох эрсдэлийг ангилж ямар нөхцлөөр аль даатгалын компанитай гэрээ хийхээ тодорхойлж болно. Харин даатгалд үл хамаарах эрсдэлийн талаар авах арга хэмжээг хэрхэн төлөвлөж байгааг тодорхойлох шаардлагатай.

4. Санхүүгийн шинжилгээ:

Сангийн сайдын 2013 оны 277 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал"-ын дагуу санхүүгийн шинжилгээг хийнэ.

№	Санхүүгийн шинжилгээний төрөл	Тайлбар
✓	Хөрөнгийн бүрэлдэхүүн, динамикийн шинжилгээ	Санхүүгийн байдлын өөрчлөлтийг харуулна.
✓	Төлбөрийн чадварын шинжилгээ	Өр төлбөрөө барагдуулах хугацаа, боломжийг харуулна.
✓	Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ	Хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээ, бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлттэй уялдуулан оршин тогтнох чадварыг харуулна.
✓	Эргэцийн шинжилгээ	Эргэлтийн хөрөнгийн нэг хэлбэрээс нөгөөд шилжих хөдөлгөөнийг илэрхийлэх бөгөөд үр ашиг нэмэгдэх боломжийг харуулна.
✓	Бүтээмжийн шинжилгээ	Хөдөлмөрийн бүтээмжийг харуулна.
✓	Үндсэн хөрөнгийн шинжилгээ	Үндсэн хөрөнгийн ашиглалтын байдлыг харуулна.
✓	Орлого үр дүнгийн шинжилгээ	Орлогын хичнээн хувь нь юунд хэрхэн зарцуулагдсаныг харуулна.
✓	Ашигт ажиллагааны шинжилгээ	Хөрөнгийн нэгж тутмаас олсон ашгийн хэмжээг илэрхийлнэ.
✓	Зах зээлийн идэвхжилтийн шинжилгээ мөнгөн урсгалын шинжилгээ	Компанийн хувьцааны эрэлтийг харуулах бөгөөд хувьцаа эзэмшигч 1 төгрөгийн ашигт хэдэн төгрөг төлж байгааг харуулна.

Мөн түүнчлэн үйл ажиллагаа эрхлэхэд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллах байдал, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрээ нэмэгдүүлэх нөөц, боломж, зах зээлийн хүртээмжтэй байдал, ашигт ажиллагаазэргийг харгалзан үзэж, үр дүнгээ тодорхойлохыг зөвлөж байна.

Журам, заавар боловсруулах зөвлөмж

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрөл тус бүрт мөрдөж ажиллах журмыг байгууллагын стратеги, зорилготой уялдуулан, Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуульд нийцүүлэн боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

Журам нь дараах үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд үйл ажиллагааны чиглэл, онцлогийг харгалзан зайлшгүй байх асуудал, нийтлэг хэрэглэгддэг нэр томъёо, баримталвал зохих зарчмуудыг тусгасан байна. Үүнд:

- Нийтлэг үндэслэл
- Нэр томъёоны тайлбар
- Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд оролцогч талууд бие биедээ харилцан итгэж, үнэн бодит мэдээллээр хангах, хууль дээдлэх, шудрага байх үндсэн зарчим
- Үйл ажиллагаанд тавигдах шаардлага, хориглох зүйлс
- Талуудын эрх үүрэг
- Гэрээ байгуулах, дуусгавар болох үндэслэл
- Хяналт хариуцлага

Зээлийн хүүгийн хэмжээг тогтоохдоо дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх нь зүйтэй.

$$IR = \frac{FC}{L} + \frac{CC}{L} + \frac{TP}{L} + \frac{OE}{L} + \frac{TC}{L} + \frac{CR}{L} + \frac{RRC}{L}$$

FC	Эх үүсвэрийн зардал
CC	Өөрийн хөрөнгийн зардал
TP	Зорилтот ашиг
OE	Үйл ажиллагааны зардал
TC	Татварын зардал
CR	Зээлийн эрсдэлийн зардал
RRC	Хөрвөх чадварын зохистой харьцааг барих алдагдсан боломжийн зардал
L	Зээлийн хэмжээ

Баталгаажуулалт

Хүсэлт гаргагч байгууллагыг төлөөлж өргөдлийг үнэн зөв бөглөсөн болохыг баталж, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага өөрийн овог, нэрийг бичиж, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна.

Б. Өргөдөлд хавсаргах баримт бичгийг бүрдүүлэх

"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 1 дүгээр хавсралтаар батлагдсан тусгай зөвшөөрлийн СЗХ02001 маягтаар гаргасан өргөдөлд, уг журмын 2 дугаар хавсралт(А)-д заасан баримт бичгүүдийг дор дурдсан шаардлагын дагуу бүрдүүлж, хавсаргана.

- ✓ Компанийн тухай хуулийн 14.3 дахь хэсэгт заасны дагуу хийсэн үүсгэн байгуулах хурлын тэмдэглэл, шийдвэрийн эх хувийг ирүүлэхдээ шийдвэрт хуралд оролцсон бүх үүсгэн байгуулагчид гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
- ✓ Үүсгэн байгуулагчид хамтран ажиллах гэрээ байгуулсан бол гэрээний эх хувийг ирүүлнэ. Гэрээнд үүсгэн байгуулагчдын хүлээх үүрэг, худалдан авах хувьцаа болон бусад үнэт цаасны ангилал, төрөл тус бүрийн тоо, үнэ, худалдан авах хугацаа зэрэг асуудлыг тусгаж, хувьцаа эзэмшигчдийн гарын үсэг, хуулийн этгээдийн тамга тэмдгээр баталгаажуулсан байна.
- ✓ Тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд бол гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг ирүүлнэ.

- ✓ Компанийн тухай хуулийн 16.2 дахь хэсэг болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 10 дугаар зүйлд нийцсэн дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталж, дүрмийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг ирүүлнэ.
- ✓ Хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан байна.
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгийг төгрөг эсхүл валютаар тухайн хуулийн этгээдийн банкинд байршуулсан болохыг нотолж, банкны тодорхойлолтыг дансны хуулгын хамт ирүүлнэ.
- ✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний иргэний цахим үнэмлэх, гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний мэргэжлийн дипломын хуулбарыг нотариатаар гэрчлүүлсэн байна.
- ✓ Эхлэлтийн тайлан тэнцлийг энэхүү зааврын хавсралтын дагуу гаргана. Бизнес төлөвлөгөөг энэхүү зааврын дагуу боловсруулна.
- ✓ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1.2-т заасны дагуу хяналт тавих ажилтныг томилох ба дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. Хяналт тавих ажилтан нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ БӨГЛӨХ, БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭХ

А. Зөвшөөрөл хүссэн өргөдлийн СЗХ02002 маягтыг бөглөх

Маягтыг бөглөхдөө техникийн үзүүлэлт, компанийн хэлбэрээс бусад тохиолдолд товчлол хэрэглэхгүй, оноосон нэр, иргэний овог нэр, он сар өдрийг бүтэн бичиж, сонгох тохиолдолд тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина.

Өргөдөл/хүсэлт гаргагч ББСБ-ын оноосон нэр нүдэнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэр, регистрийн дугаарыг бичнэ.

Зөвшөөрөл төрлийг сонгохдоо:

Хэсэг 1. Тусгай зөвшөөрлийн хүрээнд нэмж эрхлэх үйл ажиллагаа

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа нэмж эрхлэх төрлөөс тохирохыг нь сонгохдоо зээл, санхүүжилтийн баганаас сонгоно.

Хэсэг 2. Өөрийн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хоёрдогч өглөгийн гэрээгээр эх үүсвэр татахын аль нь болохыг сонгоно.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах

1. Шинээр хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн оноосон нэр, засаг захиргааны албан ёсны харьяалал, улсын бүртгэлийн гэрчилгээн дэх регистрийн дугаар хуулийн этгээдээс хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнг хувьцааны тоо, хэмжээ, хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь тус бүрээр хүснэгт дэх асуулгын дагуу нөхнө.

2. Шинээр хувьцаа эзэмшигч нь иргэн бол иргэний овог нэр, засаг захиргааны албан ёсны харьяалал, регистрийн дугаар, хувьцаа эзэмшигчээс хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнг хувьцааны тоо, хэмжээ, хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь тус бүрээр хүснэгт дэх асуулгын дагуу нөхнө.

3. Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн болон хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөлтийн талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу нөхөж, нийт хувь хөрөнгөд эзлэх хувийг тодорхойлно. Хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийн гарал үүсэл нь хууль ёсны орлогоос бүрдсэн байна.

Хоёрдогч өглөгийн гэрээгээр хөрөнгө оруулагчдын мэдээлэл

1. Хоёрдогч өглөгийн гэрээгээр хөрөнгө оруулагч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэр, регистрийн дугаар, бүртгэлийн дугаар, засаг захиргааны албан ёсны харьяалал, гэрээнд заасан хоёрдогч өглөгийн хэмжээ, хугацааг бичнэ. Хоёрдогч өглөгийн хугацаа 5 жил байна.

2. Хоёрдогч өглөгийн гэрээгээр хөрөнгө оруулагч нь иргэн бол овог нэрийг бүтэн бичиж, засаг захиргааны бүртгэлтэй албан ёсны харьяалал, регистрийн дугаар, гэрээнд заасан хоёрдогч өглөгийн хэмжээ, хугацааг бичнэ. Хоёрдогч өглөгийн хугацаа 5 жил байна.

Шинээр хувьцаа эзэмшигч, хоёрдогч өглөгийн гэрээгээр хөрөнгө оруулагчдын компанийн нэгдлийн мэдээлэл хэсгийг бөглөхдөө:

Шинэ хувьцаа эзэмшигч, хоёрдогч өглөгийн гэрээгээр хөрөнгө оруулагч бүрийн компанийн нэгдэлд хамрагддаг эсэхийг тодорхойлж, тийм, үгүй гэсэн сонголтоос тохирох нүдийг сонгож, хэрэв тийм бол хүснэгт дэх мэдээллийг СЗХ02001 маягтыг бөглөх зааварт заасны дагуу оруулна.

Хэсэг 3. Нэгж байгуулах

Нэгжийн ерөнхий мэдээлэл хэсгийг бөглөхдөө:

1. Нэгж байгуулах талаар төлөөлөн удирдах зөвлөл эсхүл хувьцаа эзэмшигчид хуралдаж, шийдвэр гаргах бөгөөд хуралдсан он, сар, өдөр, шийдвэрийн дугаарыг хүснэгтийн дагуу оруулна.

2. Нэгжийн хэлбэрийг сонгож, үйл ажиллагаа явуулах чиглэлийг тодорхой бичнэ.

3. Салбар, нэгжийн хаяг байршлын талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу оруулах ба энэ нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэмд тусгагдсан хаяг байршил байна.

4. Салбарын албан ёсны цахим хуудас, хаягийг бичнэ. Цахим хуудас байхгүй бол бөглөх шаардлагагүй.

Нэгжийн боловсон хүчний мэдээлэл, салбарын үйл ажиллагааны төлөвлөлт, үйл ажиллагаа явуулах ажлын байр, ашиглах тоног төхөөрөмж, програм хангамжийн мэдээллийг бөглөхдөө:

СЗХ02001 маягтыг бөглөх зааварт заасан зөвлөмжийн дагуу нөхнө.

Хэсэг 4. Оноосон нэр өөрчлөх

Хуулийн этгээд нь улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэр, регистрийн дугаар болон хуулийн этгээдийн шинэчилсэн нэр, оноосон нэрээ өөрчлөх болсон шалтгааныг тодорхой бичиж, гүйцэтгэх удирдлагын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна.

Хэсэг 5. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл сэргээх

Тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн хүрээнд эрхлэх үйл ажиллагааг түдгэлзүүлсэн Хорооны тогтоолын огноо, дугаарыг бөглөнө.

Баталгаажуулалт

Өргөдөл гаргагч ББСБ-ыг төлөөлж өргөдлийг үнэн зөв бөглөсөн болохыг баталж, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага өөрийн овог, нэрийг бичиж, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна.

Б. Өргөдөлд хавсаргах баримт бичгийг бүрдүүлэх

"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 1 дүгээр хавсралтаар батлагдсан зөвшөөрлийн СЗХ02002 маягтаар гаргасан өргөдөлд, уг журмын 2 дугаар хавсралт(Б)-(Е)-д заасан баримт бичгүүдийг дор дурдсан шаардлагын дагуу бүрдүүлж, хавсаргана.

1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зөвшөөрөл нэмж авах

- ✓ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нэмж авах тухай төлөөлөн удирдах зөвлөлийн хурал /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-аар хэлэлцэж, дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргах ба хурлын тэмдэглэлд хуралд оролцсон төлөөлөн удирдах зөвлөл/ байхгүй бол хувьцаа эзэмшигчид/, шийдвэрт хурлын дарга гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна.
- ✓ Банк бус санхүүгийн зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны талаар холбогдох хууль, тогтоомж, журамд нийцүүлэн дүрэмд нэмэлт өөрчлөлтийг оруулж, хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан байна.
- ✓ Бизнес төлөвлөгөөнд холбогдох өөрчлөлтийг оруулж, хувьцаа эзэмшигчдийн хурлаас батлах бөгөөд бизнес төлөвлөгөө, санхүүгийн үр ашгийн тооцоог СЗХ02001 маягтыг бөглөх зааварт заасны дагуу боловсруулна.
- ✓ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны журмыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан байна.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах

- ✓ Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах талаар хувьцаа эзэмшигчид хуралдаж дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргах ба хурлын тэмдэглэлд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид, шийдвэрт хурлын даргын гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна.
- ✓ Хувьцаа өмчлөх эрхээ өвлүүлсэн, бэлэглэсэн бол Иргэний хуульд заасны дагуу гэрээ, хэлцэл байгуулж, нотариатаар гэрчлүүлнэ.

- ✓ Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаагаа худалдахаар санал болгож байгаа хувьцаа эзэмшигч нь уг саналаа ББСБ-д мэдэгдэх бөгөөд энэ тухай бусад хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.
- ✓ Шинэ хувьцаа эзэмшигчдээс хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь тухайн хувьцаа эзэмшигчийн хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдсэн байна.
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгийг төгрөг болон валютаар тухайн хуулийн этгээд банкин дахь өөрийн дансанд байршуулсан болохыг нотолж, банкны тодорхойлолтыг дансны хуулгын хамт авна.
- ✓ Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлсэн тохиолдолд тухайн жилүүдийн санхүүгийн тайланд аудит хийлгэж, харьяалах татварын байгууллагаар баталгаажуулсан байна.
- ✓ Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбоотой өөрчлөлт оруулсан дүрэм

3. Хоёрдогч өглөг байршуулах

- ✓ Хоёрдогч өглөг байршуулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргах ба хурлын тэмдэглэлд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид, шийдвэрт хурлын дарга гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна. Хурлын тэмдэглэл, шийдвэрт эх үүсвэр татах болсон үндэслэлийг тодорхой тусгана.
- ✓ Хоёрдогч өглөгөөр хөрөнгө оруулагч нь ББСБ-тай харилцан тохиролцож, гэрээ байгуулсан байна. Хоёрдогч өглөгийн гэрээнд хугацааны эцэст хувьцаанд хөрвөх эсэхийг тодорхой заана. Хэрвээ гэрээнд хувьцаанд хөрвөхөөр тодорхой заагаагүй, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гараагүй бол хувьцаанд хөрвөхгүй болохыг анхаарна уу.
- ✓ Хоёрдогч өглөгөөр хөрөнгө оруулагчийн мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь тухайн хувьцаа эзэмшигчийн хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдсэн байна.

4. Нэгж байгуулах

- ✓ Нэгж байгуулах, салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг томилох тухай төлөөлөн удирдах зөвлөлийн хурал /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-аар хэлэлцэж, дийлэнх олонхийн саналаар шийдвэр гаргах ба хурлын тэмдэглэлд хуралд оролцсон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчид/, шийдвэрт хурлын дарга гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна.
- ✓ Нэгж байгуулахтай холбоотой өөрчлөлт оруулсан дүрэм
- ✓ Нэгжийн үйл ажиллагаанд мөрдөх журмыг боловсруулж, дотоод хяналтын журамд нэмэлт өөрчлөлт оруулан хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн баталсан байна. Дотоод хяналтын журам нь дүрмээр зохицуулагддаг бол дүрэмд нэмэлт өөрчлөлтийг оруулна.
- ✓ Салбар төлөөлөгчийн газар ажиллах гүйцэтгэх удирдлага нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.5, 13.6-д заасан шаардлагыг хангасан байх ба салбарын гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний иргэний үнэмлэх, мэргэжлийн дипломын хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.

